



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Ж.ГАН-ЭРДЭНЭ
ТАНАА

2017.02.24 № 3/330
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын үнэлгээний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Боловсролын үнэлгээний төв нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсролын үнэлгээний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу.**

Үндэсний аудитын газрын
Санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663

Аудитын менежер: Ч.Болд
Утас:261628
Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Цэрэнхүү
Утас:261628
Цахим хаяг:
Tserenkhuu_audit@gov.mn

Үндэсний аудитын газрын хаяг:
Засгийн газрын IV байр, Бага тойруу-
3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-
15160, Монгол Улс

Цахим хуудас: audit.mn

2017 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2- д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын үнэлгээний төвийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/267/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Боловсролын үнэлгээний төвийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Боловсролын үнэлгээний төвийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 15-наас 2017 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Цэрэнхүү, аудитор Р.Цолмон, П.Цэнгүүн нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Боловсролын үнэлгээний төвийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дүгээр сарын 25-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 15-наас 2016 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Боловсролын үнэлгээний төвийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Боловсролын үнэлгээний төвийн төсвийн захирагч нь Монгол улсын Боловсролын тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Төсвийн тухай хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол улсын Боловсролын тухай хуулийн 17-р зүйлд Боловсролын үнэлгээний байгууллага нь /цаашид “Боловсролын үнэлгээний төв” гэх/ сурлагын амжилт, бүх шатны боловсролын сургалтын чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах ерөнхий боловсролын түвшин, суралцагчдын мэдлэг, чадварыг тогтоох зорилго бүхий элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий хуулийн этгээд мөн” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Боловсролын үнэлгээний төвийн захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Боловсролын үнэлгээний төвийн 2016 оны төсвийг БСШУСЯ-ны Төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Боловсролын үнэлгээний төвийн үйл ажиллагааны талаар /ТАБ-СТА-А1/ маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Боловсролын үнэлгээний төвийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Боловсролын үнэлгээний төвийн төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг нийт зардлын 2% буюу 45,433.1 мянган төгрөгөөр тогтоов.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад төсвийн шууд захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. Олон улсын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Боловсролын үнэлгээний төв нь нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Боловсролын үнэлгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу БСШУСЯ-ны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 1,159,839.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 844,995.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал зардалд 2,004,834.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын нийт 7 горим, сорил гүйцэтгэв. Аудитын явцад дараах гол эрсдэлүүдийг олж тогтоов.

- Бараа материалын тооллого, тооцоо хийгээгүй, тооцоог баталгаажуулаагүй байх
- Авлага, өр төлбөрийг барагдуулаагүй байх
- Төсвийг зориулалт бусаар зарцуулсан байх

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад

баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Санхүүгийн тайланд хүмүүсээс авах авлагын үлдэгдэл 5,777.7 мянган төгрөгөөр тайлагнасан нь 2012 онд гэрээгээр ном борлуулж байсан нэр бүхий 2 ажилтан /Мөнхбат, Оюундулам/ ажлаас халагдсан, тэтгэвэрт гарсан бөгөөд уг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх хуулиудыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх

2. Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2016 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн А/115 дугаар тушаалаар тус байгууллагын няраваар ажиллаж байсан Б.Нямсүрэнгээс шинээр томилогдсон нярав Б.Саранцэцэгт бараа материалын жилийн эцсийн тооллого хийж, хүлээлцүүлэхээр шийдвэрлэсэн боловч бараа материалын тооллого хийгдээгүй, тооллогын үр дүнг баталгаажуулаагүй байгаа нь НББТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргахын өмнө", Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой ажилтан солигдох үед" тус тус хөрөнгийн тооллого хийнэ гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй, бараа материалын тулган баталгаажуулалт хийх боломжгүй байна.

Шийдвэрлэсэн: Бараа материалын жилийн эцсийн тооллого хийж, эд хөрөнгийг хүлээлцүүлэх талаар аудитын зөвлөмж өгөх,

3. Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар тус газрын нэр бүхий 35 ажиллагсдын англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх зорилгоор " Интеллегент" ХХК -тай гэрээ хийж, 26000.0 мянган төгрөг зарцуулсан боловч гэрээний хэрэгжилт нь хангалтгүй, суралцагсад нь сертификатаа бүрэн аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар ТЭЗ-тай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтаар нь зарцуулах" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Батлагдсан төсвийг зориулалтаар нь зарцуулах талаар аудитын зөвлөмж өгөх,

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын

талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц өөр чухал асуудал байхгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн
зөрчлийн нэгтгэл:**

Төсвийн шууд захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 111,883.1 мянган төгрөгийн материаллаг бус алдаа, зөрчил илэрсэн ба холбогдох зөвлөмжийг өгч ажиллаа.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Боловсролын үнэлгээний төвийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн ба аудитын дүнгээр өгсөн 4 зөвлөмжийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Зөвлөмж:

Боловсролын үнэлгээний төвийн удирдлагад өгөх 3 зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан ба илэрсэн зөрчлийн учир шалтгаан, эрсдэл буюу үр дагаварыг дэлгэрэнгүй тайлбарласан.

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсролын үнэлгээний төвийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ч.БОЛД

БЭЛТГЭСЭН:

**АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР**

**Ц.ЦЭРЭНХҮҮ
Р.ЦОЛМОН
П.ЦЭНГҮҮН**



БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Авлага3

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2

Бараа материал3

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 3

Зардал ...3

2010 оны 3 дугаар сарын
01

2017 оны 02 дугаар сар

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараахь хаягаар
харилцана уу:
Газрын захирал:

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Боловсролын үнэлгээний төвийн төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Боловсролын үнэлгээний төвийн удирдлага, холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн тайланд хүмүүсээс авах авлагын үлдэгдэл 5,777.7 мянган төгрөгөөр тайлагнасан нь 2012 онд гэрээгээр ном борлуулж байсан нэр бүхий 2 ажилтан /Мөнхбат, Оюундулам/ ажлаас халагдсан, тэтгэвэрт гарсан бөгөөд уг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн авлага нэмэгдэх, төсвийн үр ашиг буурах, холбогдох хуулийн заалт зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Дээрх хуулиудын заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2016 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн А/115 дугаар тушаалаар тус байгууллагын няраваар ажиллаж байсан Б.Нямсүрэнгээс шинээр томилогдсон нярав Б.Саранцэцэгт бараа материалын жилийн эцсийн тооллого хийж, хүлээлцүүлэхээр шийдвэрлэсэн боловч бараа материалын тооллого хийгдээгүй, тооллогын үр дүнг баталгаажуулаагүй байгаа нь НББТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргахын өмнө", Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой ажилтан солигдох үед" тус тус хөрөнгийн тооллого хийнэ гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй, бараа материалын тулган баталгаажуулалт хийх боломжгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Бараа материалын жилийн эцсийн тооллого хийж, эд хөрөнгийг хүлээлцүүлэх

Эрсдэлүүд

Бараа материал дутагдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хуулийн заалт зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар тус газрын нэр бүхий 35 ажиллагсдын англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх зорилгоор "Интеллегент" ХХК -тай гэрээ хийж, 26000.0 мянган төгрөг зарцуулсан боловч гэрээний хэрэгжилт нь хангалтгүй, суралцагсад нь сертификатаа бүрэн аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар ТЭЗ-тай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтаар нь зарцуулах" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, холбогдох хуулийн заалт зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтаар нь зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ:**ХЯНАСАН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ч.БОЛД

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.ЦЭРЭНХҮҮ
Р.ЦОЛМОН
П.ЦЭНГҮҮН

Огноо: 2017.02.23

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>128574505.00</u>	<u>85883060.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20000.00	0.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	20000.00	0.00
3121	Төгрөг	20000.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	20000.00	
33	АВЛАГА	9001295.00	5777685.00
335	Бусад авлага	9001295.00	5777685.00
3351	Байгууллагаас авах авлага	7078095.00	5777685.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1923200.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	119553210.00	80105375.00
351	Түүхий эд материал	40071620.00	44666475.00
35110	Тусгай зориулалттай материал	40071620.00	44666475.00
354	Хангамжийн материал	79481590.00	35438900.00
35410	Бичиг хэргийн материал	38466350.00	12870100.00
35420	Аж ахуйн материал	941440.00	680000.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	1900000.00	
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал	1685000.00	
35470	Бусад хангамжийн материал	36488800.00	21888800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>818754831.58</u>	<u>850477786.06</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	818754831.58	850477786.06
391	Газар		
392	Биет хөрөнгө	627620424.65	765366492.39
39201	Барилга, байгууламж, орон сууц		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89447825.00	65629400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-69622277.02	-62211201.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	727331360.00	1064926250.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-251260200.70	-399384385.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	173110055.50	169739450.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41982451.98	-73315198.69
39214	Бусад үндсэн хөрөнгө	2586840.00	1534840.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1990726.15	-1552661.99
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном		
393	Биет бус хөрөнгө	191134406.93	85111293.67
39301	Програм хангамж	233626960.00	218114560.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-42492553.07	-133003266.33
39303	Бусад биет бус хөрөнгө		
39304	Хуримтлагдсан элэгдэл		
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.00	0.00
39401	Биологийн хөрөнгө /ТӨҮГ/		
39402	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/		

39403	Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/		
39404	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/		
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>947329336.58</u>	<u>936360846.06</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>947329336.58</u>	<u>936360846.06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	947329336.58	936360846.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	344839013.00	344839013.00
51101	Өмч: - төрийн	344839013.00	344839013.00
512	Хуримтлагдсан үр дүн	602220149.28	591363648.63
51210	Өмнөх үеийн үр дүн	602220149.28	602332139.15
51220	Тайлант үеийн үр дүн		-10968490.52
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	270174.30	
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		158184.43
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>947329336.58</u>	<u>936360846.06</u>

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2413275498.00	2260385182.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	743843598.00	991662082.16
120	Нийтлэг татварын бус орлого	743843598.00	991662082.16
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого	20000.00	
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	743823598.00	991662082.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	499850698.00	814125082.16
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25495300.00	30202000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	218477600.00	147335000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1669431900.00	1268723100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1557431900.00	1212878100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1557431900.00	1212878100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	112000000.00	55845000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		54000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	112000000.00	1800000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		45000.00
131106	Төсвийн урамшуулал		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЫН ДҮН	1894481829.81	2271353672.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1894481829.81	2271353672.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1743101584.04	2207288408.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	510866649.00	465945750.00
210105	Гэрээт ажлын хөлс	51205546.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48436072.06	52113280.00
210201	Тэтгэврийн даатгал	32929408.06	33212270.00
210202	Тэтгэмжийн даатгал	2454531.00	2378641.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2763069.00	2355738.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2536058.00	4719650.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7753006.00	9446981.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93130000.00	91800000.00
210304	Байрны түрээс	93130000.00	91800000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	25035835.40	33593545.00
210401	Бичиг хэрэг	7295757.40	13996370.00
210402	Тээвэр, шатахуун	6171000.00	8575000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11186578.00	9084175.00
210404	Ном, хэвлэл	382500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1938000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	10195000.00
210604	Урсгал засвар		10195000.00
2107	Томилолт, зочны зардал	17309613.00	768225.00
210701	Гадаад албан томилолт	16816613.00	
210702	Дотоод албан томилолт	493000.00	768225.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96415455.00	186136794.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27321975.00	36002674.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		2500000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	276500.00	276500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2032000.00	3273000.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	66784980.00	144084620.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	951907959.58	1366735814.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7355540.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	822380524.00	906404269.22
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122171895.58	460331545.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151380245.77	64065263.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	145470245.77	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	145470245.77	
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	5910000.00	6545000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5910000.00	6545000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	57520263.94
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		57520263.94
213504	Хөрөнгийн		
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	518793668.19	-10968490.52
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	518793668.19	-10968490.52

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2203205183.00	3139699165.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	533773283.00	1861122204.16
120	Нийтлэг татварын бус орлого	533773283.00	1861122204.16
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого	20000.00	
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	533753283.00	1861122204.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	508257983.00	814773492.16
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25495300.00	1046348712.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1669431900.00	1278576961.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1557431900.00	1212878100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1557431900.00	1212878100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	112000000.00	55845000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		54000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	112000000.00	1800000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		45000.00
131106	Төсвийн урамшуулал		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	9853861.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		9853861.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1794454123.00	2794999665.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1794454123.00	2794999665.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1641388877.23	2731484401.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548014639.08	295365272.00
210101	Үндсэн цалин	243620259.08	213267372.00
210102	Нэмэгдэл	53203890.00	47883500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34214394.00	34214400.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	216976096.00	
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38133500.00	33266000.00
210201	Тэтгэврийн даатгал	24844529.00	21169300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2658000.00	2419300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3322800.00	3024200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	664800.00	604800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6643371.00	6048400.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92320000.00	91800000.00
210304	Байрны түрээс	92320000.00	91800000.00

210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	53282758.00	33091195.00
210401	Бичиг хэрэг	32139105.00	13494020.00
210402	Тээвэр, шатахуун	7711000.00	8575000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11186368.00	9084175.00
210404	Ном, хэвлэл	757855.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1488430.00	1938000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	360800.00	10200000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	360800.00	
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар		10200000.00
2107	Томилолт, зочны зардал	17309613.00	768225.00
210701	Гадаад албан томилолт	16816613.00	
210702	Дотоод албан томилолт	493000.00	768225.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	187010975.00	355212015.22
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31827975.00	220332215.22
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		2500000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	276500.00	276500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3880000.00	3273000.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	151026500.00	128830300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	704956592.15	1911781694.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1303340.00	1012796712.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	703653252.15	898984982.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153065245.77	63515263.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	145470245.77	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	145470245.77	
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	7595000.00	5995000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7595000.00	5995000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	57520263.94
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		57520263.94
213504	Хөрөнгийн		
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>408751060.00</u>	<u>344699500.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	408731060.00	344719500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	408731060.00	344719500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	408731060.00	344719500.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	408731060.00	344719500.00
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-408731060.00</u>	<u>-344719500.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20000.00	-20000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		20000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20000.00	

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2015 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	344,839,013.00	270,174.30	83,426,481.09		428,535,668.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344,839,013.00	270,174.30	83,426,481.09	0.00	428,535,668.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			518,793,668.19		518,793,668.19
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	270,174.30	602,220,149.28	0.00	947,329,336.58
D01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	344,839,013.00	270,174.30	1,121,013,817.47	0.00	947,329,336.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			111,989.87		111,989.87
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344,839,013.00	270,174.30	602,332,139.15	0.00	947,441,326.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-111,989.87			-111,989.87
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-10,968,490.52		-10,968,490.52
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	591,363,648.63	0.00	936,360,846.06

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				20,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,072,747,900.00	1,952,643,925.08	2,182,578,100.00	2,004,834,828.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,072,747,900.00	1,952,643,925.08	2,182,578,100.00	2,004,834,828.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,060,597,900.00	1,945,048,925.08	2,175,578,100.00	1,998,839,828.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	550,504,800.00	533,564,639.08	302,417,900.00	282,161,411.00
210101	Үндсэн цалин	244,800,000.00	229,170,259.08	220,320,000.00	200,063,511.00
210102	Нэмэгдэл	53,203,900.00	53,203,890.00	47,883,500.00	47,883,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,214,400.00	34,214,394.00	34,214,400.00	34,214,400.00
210104	Урамшуулал				
210105	Гэрээт ажлын хөлс	218,286,500.00	216,976,096.00		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,544,000.00	36,544,000.00	33,266,000.00	33,266,000.00
210201	Тэтгэврийн даатгал	23,255,029.00	23,255,029.00	21,169,300.00	21,169,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,658,000.00	2,658,000.00	2,419,300.00	2,419,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,322,800.00	3,322,800.00	3,024,200.00	3,024,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	664,800.00	664,800.00	604,800.00	604,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,643,371.00	6,643,371.00	6,048,400.00	6,048,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,650,000.00	92,320,000.00	91,800,000.00	91,800,000.00
210301	Гэрэл, цахилгаан				
210302	Түлш, халаалт				
210303	Цэвэр, бохир ус				
210304	Байрны түрээс	92,650,000.00	92,320,000.00	91,800,000.00	91,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,669,100.00	53,282,758.00	35,916,700.00	33,091,195.00
210401	Бичиг хэрэг	35,072,100.00	32,139,105.00	13,506,500.00	13,494,020.00
210402	Тээвэр, шатахуун	11,710,500.00	7,711,000.00	9,727,700.00	8,575,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,424,500.00	11,186,368.00	10,741,200.00	9,084,175.00
210404	Ном, хэвлэл	462,000.00	757,855.00		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал				
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,488,430.00	1,941,300.00	1,938,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				
2105	Нормативт зардал	0.00	0.00	0.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл				
210502	Хоол, хүнс				
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	222,800,000.00	209,239,580.00	194,601,800.00	184,920,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	222,800,000.00	209,239,580.00	179,750,000.00	174,720,000.00
210602	Тавилга				
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл				
210604	Урсгал засвар			14,851,800.00	10,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	40,799,300.00	17,309,613.00	22,054,300.00	768,225.00
210701	Гадаад албан томилолт		16,816,613.00		
210702	Дотоод албан томилолт	40,799,300.00	493,000.00	22,054,300.00	768,225.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	204,564,300.00	187,010,975.00	416,576,800.00	355,212,015.22
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,000,000.00	31,827,975.00	249,488,700.00	220,332,215.22
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох				
210803	Даатгалын үйлчилгээ			2,500,000.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	276,500.00	276,500.00	276,500.00	276,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо				
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	3,880,000.00	5,000,000.00	3,273,000.00
210807	Газрын төлбөр				
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж				
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	156,287,800.00	151,026,500.00	159,311,600.00	128,830,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	847,066,400.00	815,777,360.00	1,078,944,600.00	1,017,620,982.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,375,000.00	1,303,340.00		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	844,691,400.00	814,474,020.00	1,078,944,600.00	1,017,620,982.00
211	ХҮҮ	0.00	0.00	0.00	0.00
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	0.00	0.00	0.00
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр				
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	0.00	0.00	0.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр				
212	ТАТААС	0.00	0.00	0.00	0.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0.00	0.00	0.00	0.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас				
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.00	0.00	0.00	0.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас				
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,150,000.00	7,595,000.00	7,000,000.00	5,995,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00	0.00	0.00

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг				
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг				
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,150,000.00	7,595,000.00	7,000,000.00	5,995,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж				
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж				
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,150,000.00	7,595,000.00	7,000,000.00	5,995,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал				
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт				
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж				
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал				
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	0.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	0.00	0.00	0.00
220001	Барилга байгууламж				
221001	Их засвар				
222001	Тоног төхөөрөмж				
223001	Бусад хөрөнгө				
224001	Стратегийн нөөц хөрөнгө				
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00	0.00	0.00
226001	Гадаад эх үүсвэрээр				
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00	0.00	0.00
230001	Эргэж төлөгдөх зээл				
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл				
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл				
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,072,747,900.00	1,952,643,925.08	2,182,578,100.00	2,004,814,828.22
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,566,131,800.00	1,418,990,642.08	1,217,918,100.00	1,159,839,336.06
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,566,131,800.00	1,418,990,642.08	1,217,918,100.00	1,159,839,336.06
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих				
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих				
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих				
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	0.00
132001	Орон нутгийн төсвөөс				
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих				
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих				
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	506,616,100.00	533,653,283.00	964,660,000.00	844,975,492.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	490,616,100.00	508,157,983.00	941,660,000.00	814,773,492.16
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,000,000.00	25,495,300.00	23,000,000.00	30,202,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих				
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих				
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	0.00
122001	Хандив тусламж /дотоод/				
122002	Хандив тусламж /гадаад/				
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	0.00
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх				
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		20,000.00		20,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	0.00	0.00	0.00
610001	Төсвийн байгууллага				
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	39.00	24.00	36.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	37.00	38.00	23.00	35.00
620003	Үйлчлэх ажилтан				
620004	Гэрээт ажилтан				
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	0.00	0.00	0.00	0.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	0.00	0.00	0.00	0.00
630001	Төрийн өмчит ЕБС				
630002	Хувийн ЕБС				
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	0.00	0.00	0.00	0.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага				
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага				
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	0.00	0.00	0.00	0.00
632001	Төрийн өмчит МСҮТ				
632002	Хувийн МСҮТ				
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	0.00	0.00	0.00	0.00
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо				
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо				
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо				
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24.00	38.00	24.00	36.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)				
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)				
650003	Ажлын албаны албан хаагч (АА)				

650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)				
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)				
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)				
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)				
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)				
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	24.00	38.00	24.00	36.00
650010	Гэрээт ажилтан				
650011	Улс төрийн албан хаагч (УТ)				